

### 1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 25.8 хувиар өсч 18.7 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 11.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 6.8 нэгж хувийг валютын харилцах, 5.3 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн байна.

#### M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 25.8%-иар нэмэгдсэн байна.




Нийт хадгаламжийн хэмжээ 12.6 их наяд төгрөгт хүрснээс 84.6 хувь буюу 10.6 их наяд төгрөг нь иргэдийн, 15.4 хувь буюу 1.9 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 23.2 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байгаагаас иргэдийн хадгаламжийн 20.1 хувийг, байгууллагын хадгаламжийн 40.7 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

#### Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 20.4%-иар өсч 12.6 их наяд ₮-т хүрчээ.




Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 318.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Тодруулбал төгрөг болон гадаад валютын хадгаламжийн өсөлтийг иргэдийн хадгаламжийн өсөлт тайлбарлаж байна. Харин гадаад валютын харилцахын буурсан нь санхүүгийн байгууллагын харилцах буурсантай холбоотой байна.

#### M2 өмнөх сараас 318.8 тэрбум ₮-өөр өсөв.



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.3 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн -7.8 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 16.6 нэгж хувийг ГЦА-ын өсөлт, үлдсэн 9.2 нэгж хувийг ДЦА-ын өсөлт бүрдүүлжээ. ГЦА-ын өсөлтийг Төв Банкны ГЦА буюу банкуудын гадаад валютын харилцах болон алтны харилцахын өсөлт бүрдүүлж байна. Харин ДЦА-ын өсөлт хадгаламжийн байгууллагын олгосон зээлийн өсөлттэй холбоотой байна.


#### M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



## 2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 28.2 хувиар өсч 8.5 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 16.9 хувиар өсч 7.9 их наяд төгрөгт тус тус хүрчээ.


### Нийт зээлийн үлдэгдэл 16.6 их наяд ₮ -т хүрч, жилийн 23.8%-иар өсөв.



Нийт зээлийн үлдэгдлийн 17.5 хувь буюу 2.9 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна. Тодруулбал иргэдийн зээлийн 1.7 хувь нь, хувийн байгууллагын 34.8 хувь нь гадаад валютын зээл байна.

Тайлант сард нийт шинээр олгосон зээл өмнөх сараас 60.3 тэрбум төгрөгөөр өсч, эргэн төлөгдсөн зээл 280.1 тэрбум төгрөгөөр буурчээ. Олгосон зээлийн 13.5 хувь буюу 290.7 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

**Тайлант сард 2,146.9 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1,706.5 тэрбум ₮ эргэн төлөгдлөө.**



Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.4 нэгж хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 0.6 нэгж хувиар буурсан байна. Нийт чанаргүй зээлийн 87.3 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 83.1 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.


### Чанаргүй зээл нь нийт зээлийн 12.4%, хугацаа хэтэрсэн зээл 5.8% байна



Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 2,060.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 106.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эдгээр зээлийн 25.7 хувь нь гадаад валютаар олгогджээ.


Чанаргүй зээлийн 26.4 хувийг уул уурхай, 19.1 хувийг боловсруулах, 13.2 хувийг барилга, 12.5 хувийг худалдааны салбарын зээл эзэлж байна.

### Нийт чанаргүй зээлийн 87.3 хувь нь хувийн байгууллагын, 12.2 хувь нь иргэдийн зээл




Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 5.9 тэрбум төгрөгөөр өсчээ. Тайлант сард уул уурхайн салбарын зээл 51.6 тэрбум, барилгын салбар 17.2 тэрбум, боловсруулах салбар 5.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Харин худалдааны салбарын зээл 112.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах, уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна**



Тайлант сард хувийн байгууллагад 877.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 30.6 хувь буюу 268.5 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Худалдаа, уул уурхай, боловсруулах, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.

**Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц**



Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 336.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс цалин, тэтгэврийн зээл 181.3 тэрбум төгрөг, хадгаламж барьцаалсан зээл 66.6 тэрбум төгрөг, автомашины зээл 14.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**Иргэдийн зээлийн 38 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлж байна.**




Тайлант сард иргэдэд 1,229.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 1.8 хувь буюу 22.3 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Иргэдэд олгосон зээлийн дийлэнхи буюу 69.4 хувийг цалин тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, картын зээл бүрдүүлсэн байна.

**Иргэдэд олгосон зээлийн бүтэц**



**ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах, барилгын салбарын зээл эзэлж байна**




ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 3,315,9 тэрбум төгрөгт хүрснээс 30.1 хувийг худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 16.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 13.0 хувийг барилгын салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 7.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 18.2 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

**3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ**

Нийт ипотекийн зээл 93781 зээлдэгчийн 4.38 их наяд төгрөг байна. Хөтөлбөрийн эх үүсвэрээр 69220 зээлдэгчид 3.28 их наяд төгрөгийн зээл олгожээ.


**Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өсчээ.**



Орон нутгийн ипотекийн зээл<sup>1</sup>-ийн 77.7 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.5 хувь нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.0 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.2 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.


**Нийт ипотекийн зээлийн 75.0 хувийг хөтөлбөрийн зээл эзэлж байна.**



Нийт зээлийн 933.3 тэрбум төгрөг буюу 21.3 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 17.3 хувь болох 759.7 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.

<sup>1</sup> Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

**Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.3 хувь нь орон нутагт байршилтай орон сууцанд олгожээ.**



Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.8 хувь нь хэвийн, 2.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээл байна.

**Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 986.4 сая төгрөгөөр чанаргүй зээл 2933.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.**



Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 58.14 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 40.23 хувийг хөтөлбөрийн зээл, 1.63 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 89.8 хувь буюу 3.94 их наяд төгрөг 80 м.кв хүртэлх талбайтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.


Нийт ипотекийн зээл авсан зээлдэгчдийн 76.6 хувь нь 18-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80.3 хувь болох 3.52 их наяд төгрөгийг бүрдүүлж байна.

**Ипотекийн зээлийн 82.7 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.**



Тайлант сард 73.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 54.7 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 45.3 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

**Тайлант сард шинээр 957 зээлдэгчдэд ипотекийн зээл шинээр олгожээ.**



Тайлант сард ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 93781 байгаагийн 62.8 хувь нь сарын 2.0 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой зээлдэгчид байна.

**Ипотекийн зээлийн дундаж хүү өмнөх сараас 2.3 нэгж хувиар буурчээ.**



#### 4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ


Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах ханш аажмаар суларсаар сарын эцсийн байдлаар 2627.04 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 2.4 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2581.88 төгрөг байв.

**Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулав.**



Төгрөгийн юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 2.8 хувиар суларч 378.3 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 368.4 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 378.3 төгрөг байлаа.

**Төгрөгийн ханш юаны эсрэг суларсан байна.**



#### 5. ХҮҮ


2018 оны 11 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.6 хувь буюу өмнөх оны үеэс 0.6 нэгж хувиар буурсан байна. Гадаад валютын хүү өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурч 4.1 хувьд хүрсэн байна.

**Шинээр татсан нийт хадгаламжийн хэмжээ, хүү**



Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.2 хувьтай бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт гадаад валютын олгосон зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар буурч 10.5 хувьд хүрчээ.


**Шинээр олгосон нийт зээлийн хэмжээ, хүү**



Иргэдээс татсан төгрөгийн хадгаламж 12.2 хувь, хувийн байгууллагаас татсан хадгаламж 10.2 хувийн хүүтэй байна.

Тайлант сард шинээр татсан нийт төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.6 хувьтай байна. Эдгээр хадгаламжийн дийлэнх нь 12-15 хувьтай татжээ.

### Шинээр татсан нийт ₮-ийн хадгаламжийн хүүний тархалт




2018 оны 11 дүгээр сард нийт төгрөгийн хадгаламжийн ЖДХ 12.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 5.3 хувьтай байна. Тайлант сард иргэдийн хадгаламжийн үлдэгдлээрх ЖДХ 12.2 хувь, гадаад валютын хүү 5.2 хувьтай байгаа бол тухайн сарын хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.6 хувь, гадаад валютын хүү 5.4 хувьтай байна.

Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 17.4 хувь, гадаад валютын зээлийн хүү 8.8 хувьтай байна. Харин хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.2, валютын зээлийн ЖДХ 10.6 хувьтай байна.


Тухайн сард шинээр олгосон нийт төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 17.2 хувьтай байна. Эдгээр зээлийн дийлэнх нь 16-18 хувьтай олгосон байна.

### Шинээр олгосон нийт ₮-ийн зээлийн хүүний тархалт




Мөн тайлант сард нийт төгрөгийн зээлийн үлдэгдлээрх ЖДХ 17.3 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.7 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.4 хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 13.3 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.5 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.6 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар, гадаад валютын зээлийн ЖДХ 0.6 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү**




**Нийт зээлийн үлдэгдэл, хүү**




Тайлант сарын нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 12.2 хувьтай байна. Эдгээр хадгаламжийн дийлэнх нь 13-15 хувьтай байна.

Тухайн сарын нийт төгрөгийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 17.3 хувьтай байна. Эдгээр зээлийн дийлэнх нь 16-18 хувийн хүүтэй байна.

**Нийт ₮-ийн хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт**



**Нийт ₮-ийн зээлийн үлдэгдлийн хүүний тархалт**





## 6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 9.3 хувьд хүрч өмнөх сараас нэмэгдсэн байна. Үүнээс 7.3 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 2.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хатуу түлш, автобензин, эм, тариа, хувцасний үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд мах болон сүүний үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Харин хүнсний ногооны үнэ буурсан байна.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 2.2 хувьд хүрсэн байна. Өмнөх сараас үнийн түвшин нэмэгдэхэд хүнсний бараа 0.5 нэгж хувийг, хүнснээс бусад бараа 1.7 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний барааны үнэ өсөхөд махны үнийн өсөлт нөлөөлсөн бол хүнснээс бусад бараа өсөхөд хатуу түлш, бэлэн хувцас, автобензиний үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 9.3 хувь




УБ хотын сарын инфляци 2.2 хувь




ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц



Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ

Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл

Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)



Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.9 Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц




Зураг 2.11. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум/



Зураг 2.10. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.11. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь



### 3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр





Зураг 3.3. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар

Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар





Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл



Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он

Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт

Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

